

**2018 ОНЫ 10 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 6 байгууллага /УНТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, ГССҮТ, НЭМГ/ мэдээ ирүүлсэн.

Нэг. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:

2018 оны 10 дугаар сард хүлээгдлийн мэдээ ирүүлсэн байгууллагуудаас УНТЭ амбулаторийн үзлэг 321, УГТЭ 106 хүлээгдэл бүртгэгдсэн байна. Өмнөх сарын хүлээгдэлтэй харьцуулахад УГТЭ 8 тохиолдлоор хүлээлгийн тоо нэмэгдэж, УНТЭ-ийн хүлээгдэл 1 тохиолдлоор буурсан байна.

УНТЭ-ийн амбулаторийн 8 кабинетэд нийт 321 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдэж, өмнөх сарын хүлээгдлээс 1 үйлчлүүлэгчээр буурсан байна. Үүнд:

- Зүрх судасны кабинет 98
- Уушигны кабинет 1
- Мэдрэлийн кабинет 56
- Нүдний кабинет 24
- Нүдний даралтын кабинет 12
- Чих хамар хоолойн кабинет 3
- Урологийн кабинет 37
- Хоол боловсруулах эрхтэн судлалын кабинет 90 тус бүр 1-14 хоногийн хугацаатай хүлээсэн байна. 16 кабинет хүлээгдэлгүй ажиллажээ.

УГТЭ-г 2 кабинетэд 102 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Зүрх судасны кабинет 59, мэдрэлийн кабинет 43 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 4 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. 12 кабинет хүлээгдэлгүй ажилласан байна.


ХСҮТ-ийн амбулаторийн 12 кабинетэд нийт 403 үйлчлүүлэгч үйлчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 336 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Үүнд:

- Зүрх судасны кабинет 39
- Элэг цөс нойр булчирхайн кабинет 19
- Толгой хүзүүний мэс заслын кабинет 28
- Хими эмчилгээний кабинет 57
- Эмэгтэйчүүдийн мэс заслын кабинет 44
- Ерөнхий мэс заслын кабинет 13
- Цээжний хөндийн мэс заслын кабинет 51
- Гепатологийн кабинет 96
- Сэргээн засах 1
- Туяа эмчилгээний кабинет 23
- Хөнгөвчлөх эмчилгээний кабинет 5

- Ангиографийн кабинет 27 үйлчлүүлэгч тус бүр 1-7 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 157 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

ЭХЭМҮТ, ГССҮТ-үүд нь амбулаторийн хүлээгдэлгүй байна.

УНТЭ, УГТЭ-ийн 10-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2018 оны 10 дугаар сард УНТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн оношлогооны тасгуудад хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УНТЭ-т оношлуулахаар 162 үйлчлүүлэгч 2-14 хоног хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 24 үйлчлүүлэгчээр буурсан байна. Үүнд:

- Рентген зураг 57
- Зүрхний цахилгаан бичлэг 2
- Хэвлийн эхо 4
- Зүрхний ачаалалтай сорил 3
- Бүдүүн гэдэсний дуран 51
- Тархины цахилгаан бичлэг 9
- MRI 1
- Захын судасны ЭХО 2
- Уушигны дуран 2
- Урологийн оношилгооны дуран 31 үйлчлүүлэгч оношлуулахаар 2-14 хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна.


УГТЭ-т оношлуулахаар 51 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна. Үүнд:

- Хэвлийн эхо 40
- Тархины цахилгаан бичлэг 5
- Допплерографи 6 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 226 үйлчлүүлэгч байна.

ХСҮТ-д анх удаа үзүүлэхээр дугаар авсан 220 үйлчлүүлэгчээс өдөртөө үйлчлүүлсэн 76 үйлчлүүлэгч, 7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй 73, 1-6 хоногийн хүлээгдэлтэй 71 үйлчлүүлэгч байна. Үүнд: Бүдүүн шулуун гэдэсний дуран 1 үйлчлүүлэгч, КТГ 1 үйлчлүүлэгч, уушигны дуран 3, ходоодны дуран 24, хэвлийн ЭХО 75, зүрхний цахилгаан бичлэг 40 үйлчлүүлэгч тус бүр 1-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.

Өдөртөө үйлчлүүлсэн 76 үйлчлүүлэгч байна.

УНТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн оношлогооны кабинетийн 10-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



Гурав. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн лабораторийн шинжилгээний хүлээгдэл:


2018 оны 10 дугаар сард УНТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, ГССҮТ эмнэлгүүд лабораторийн шинжилгээний хүлээгдэлгүй.

УГТЭ-т лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэн мэдээлсэн байна. УГТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 58 үйлчлүүлэгч 1 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд:

- Цусны ерөнхий шинжилгээ 19
- Биохимийн шинжилгээ 39

Иммунолог, серологи, цитологи, бактериологи, шээсний ерөнхий шинжилгээ хүлээгдэлгүй. Өдөртөө үйлчлүүлсэн 433 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-ийн лабораторийн кабинетийн 10-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



Дөрөв. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2018 оны 10 дугаар сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УНТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ бүртгэн мэдээлсэн. ГССҮТ-ийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэлгүй байна.

УНТЭ-т 10-р сард нийт 15 үйлчлүүлэгч 1 хоногоос 14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: Урологийн тасагт 3, чих хамар хоолойн тасагт 7, уушигны тасагт 5 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т 10-р сард нийт 106 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнээс: Чих хамар хоолойн тасагт 45, мэдрэлийн мэс засалд 25, хоол боловсруулах эмгэг судлалын тасаг 13, уушигны тасагт 15, мэс заслын тасагт 5, уламжлалт эмчилгээний тасагт 3 үйлчлүүлэгч тус тус 1-30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

ХСҮТ-д 10-р сард нийт 254 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд: 1-3 хоногийн хугацаанд 67 үйлчлүүлэгч, 3-6 хоногийн хүлээгдэлтэй 66 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 69 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 42 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хүлээгдэлтэй 10 үйлчлүүлэгч байна.

ХСҮТ нь яаралтай тусламжаар өдөрт дунджаар 10 өвчтөн ирдэг, нийт ирж буй үйлчлүүлэгчдийн 98% нь хорт хавдрын хожуу шатандаа орсон өвчтөнүүд байдаг ба үүнээс хэвтэх шаардлагатай өвчтөнүүдийг хөнгөвчлөх болон бусад мэс заслын тасгуудад хэвтүүлдэг учир орны зөрүүтэй байдал үүсдэг.

Химийн тасгаар өвчтөн 14-21 хоногийн давтамжтай “товлолт” эмчилгээнд хамрагддаг тул хүлээгдэлтэй харагдаж байна

Ангиографийн тасаг нь өдөрт дунджаар 10 өвчтөнд ажилбар хийдэг ба тус тасгийн дундаж ор хоног 1.6 тул ажилбар хийлгэхээр хүлээж буй өвчтөний тоо их байна.

ЭХЭМҮТ-ийн эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасагт 2 үйлчлүүлэгч 1-3 хоног хэвтэх ор хүлээж байна.

Тав. НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

НЭМГ-ын харьяа 11 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан дүүргийн дотор 118, мэдрэл 65, Хан уул дүүргийн эрүүл мэндийн төвийн дотор 33, мэдрэл 30, Наркологийн төв 59 үйлчлүүлэгч тус бүр 1-14 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2018 оны 10-р сарын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг хүснэгтээр харуулав.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2018 оны 10 сарын хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлийн мэдээ

№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	СХД ЭМТ	ХУД ЭМТ	ЧД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	СБД НЭ	ХУД НЭ	СХД НЭ	Наркологийн төв
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	65	30	0	7	25	15	0	0	1	0	0

		1-3 хоног		8		3		2			1		
		3-6 хоног		12		2	3	13					
		7-14хоног	22	10		2	10						
		15-30 хоног	36				12						
		1 сараас дээш	7										
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтний тоо	118	33	61	26	3	23	6	0	14	0	0
		1-3 хоног		10	38	3		13	6		14		
		3-6 хоног		14	19	13	3	10					
		7-14хоног	19	6	4	10							
		15-30 хоног	36	3									
		1 сараас дээш	63										
3	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	68	0	0	0	0	16	0	0	0	0	0
		1-3 хоног						10					
		3-6 хоног	13					6					
		7-14хоног	16										
		15-30 хоног	39										
		1 сараас дээш											
4	Наркологийн тусламж үйлчилгээ	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	59
		1-3 хоног											23
		3-6 хоног											34
		7-14хоног											2
		15-30 хоног											
		1 сараас дээш											


Нийслэлийн түргэн тусламжийн төвд 10 дугаар сард 26741 дуудлага бүртгэгдсэний 37.4%-ийг 0-20 минутад, 30.6%-ийг 21-40 минутад, 17.8%-ийг 41-60 минутад, 14.2%-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 10 сард ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/

№	Үзүүлэлт		10 сар	
			Дуудлагын тоо	Хувь
1	Нийт дуудлага		26741	100%
2	Хүлээгдлийн минут	0-20 минут	10011	37.4%
3		21-40 минут	8177	30.6%

4	41-60 минут	4764	17.8%
5	1 цагаас дээш	3789	14.2%

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн тусламж үйлчилгээний 2018 оны сүүлийн 6 сарын хүлээгдлийн мэдээг графикаар харуулахад:



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА